



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/513

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар болон Ховд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, "АЛСЫН ХАРАА-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, зорилт шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчилах зардалд зориулж 24000000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 24000 000 төгрөг /Хорин дөрвөн сая /-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн 5.35 тусгагдсан Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөрөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

